


БАТЛАВ:

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

  
Г.ЧИНЗОРИГ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ



Л.АРЦСОД

2021 оны 07 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар ГЗ/2142

Улаанбаатар хот

Нэг талаас Харилцаа холбооны зохицуулах хороо, түүнийг төлөөлж Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга албан тушаалтай **З.Эрдэнэчулуун** /цаашид “захиалагч” гэх/, нөгөө талаас Говь хэнтий ХХК-ийг төлөөлж менежер **Ч.Цэнхэрцэцэг** нар /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дор дурдсан нөхцлөөр энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав.

#### Нэг. Нийтлэг заалт

- 1.1 Гүйцэтгэгч нь захиалагч талын даалгавараар “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 6-р хороо, Сүхбаатарын гудамж-13 Бага тойруу Метро бизнес төв Б корпус 1203 тоот өрөөний засварын ажил энэхүү гэрээний хавсралтад заагдсан ажлыг хийж гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2 Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

#### Хоёр. Гэрээний үнэ, төлбөр төлөгдөх хугацаа

- 2.1 Гэрээний нийт үнэ **18.779.950₮** /арван найман сая долоон зуун далан есөн мянга есөн зуу тавь) төгрөг байна. Гэрээний үнэд энэхүү гэрээний хавсралтад заасан ажил үйлчилгээг хийхтэй холбоотой бүх ажил үйлчилгээний зардал, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төлөгдөх татвар, НӨАТ орсон болно.
- 2.2 Захиалагч нь гэрээ байгуулсаны дараа урьдчилгаа 60% болох **11.267.970₮** (арван нэгэн сая хоёр зуун жаран долоон мянга есөн зуун дал) төгрөгийг, ажил дуусаж хүлээлгэж өгсөний дараа үлдэгдэл 40% болох **7.511.980₮** (долоон сая таван зуун арван нэгэн мянга есөн зуун ная) төгрөгийг гүйцэтгэгчийн “Хаан банкны” 5133093931 тоот дансанд шилжүүлнэ.
- 2.3

#### Гурав. Гэрээний хугацаа

- 3.1 Ажил гүйцэтгэх хугацааг талууд харилцан тохиролцож тогтоосноор **2021 оны 08 дугаар сарын 05-наас 2021 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хооронд** хийж гүйцэтгэнэ.

#### Дөрөв. Захиалагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг

- 4.1 Захиалагч нь энэ гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, зохих хөлсийг хугацаанд нь төлнө.
- 4.2 Захиалагч нь гүйцэтгэгчийн дотоод ажилд оролцохгүйгээр зураг төсөл, ажлын явц, чанар, үр дүнд хяналт тавина.




- 4.3 Ажил гүйцэтгэгч нь гэрээний нөхцлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн дутагдал байвал захиалагч дор дурдсан шаардлагуудыг тавих эрхтэй.
- 4.3.1 Буруу буюу дутуу гүйцэтгэсэн ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэгч талын зардлаар засах буюу гүйцээлгэх.
- 4.3.2 Ажлын хөлсийг зохих хэмжээгээр хорогдуулах;
- 4.3.3 Ажлын дутагдлыг захиалагч өөрийн хөрөнгөөр засахад зайлшгүй гарсан зардлыг төлүүлэх.
- 4.4 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдээ гэрээг ноцтой зөрчсөн буюу бусад ноцтой дутагдал гаргасан байвал захиалагч нь гэрээг цуцалж, учирсан хохирлыг төлүүлэхээр шаардах эрхтэй.
- 4.5 Захиалагч тал нь гүйцэтгэгч талаар цаг үеийн шинжтэй, нэмэлт ажил хийлгэж болох бөгөөд энэ тохиолдолд гүйцэтгэх ажил, төсөв зэргийг тухайн үед харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 4.6 Энэхүү гэрээний 4.5-д заасан нэмэлт ажил гүйцэтгэсэн тохиолдолд гүйцэтгэсэн ажлын зураг төсөл, төсөв, холбогдох баримтыг энэхүү гэрээнд хавсаргана.
- 4.7 Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал түүнийг гүйцэтгэгч тал захиалагчийн тогтоосон хугацаанд арилгах үүрэгтэй.

#### **Тав. Гүйцэтгэгчийн эдлэх эрх, хүлээх үүрэг**

- 5.1. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг тогтоосон хугацаанд биечлэн, захиалагчийн шаардлагын хүрээнд чанартай хийж гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.2. Гүйцэтгэгч нь захиалагчаас буцааж өгөхөөр авч ашигласан материал болон бусад зүйлсийг ажлын явц дууссаны дараа захиалагч талд хүлээлгэн өгнө.
- 5.3. Ажлын явцын талаар захиалагчтай байнга холбоотой ажиллахын зэрэгцээ шаардлагатай мэдээллийг тухай бүр өгч байна.
- 5.4. Гүйцэтгэгч тал нь гэрээт ажлын гүйцэтгэх хугацаанд хөдөлмөр хамгаалал аюулгүй ажилгааг бүрэн хариуцаж ажиллана.
- 5.5. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол гарсан тохиолдолд үл маргах журмаар захиалагчийн тогтоосон хугацаанд арилгах үүрэгтэй.

#### **Зургаа. Талуудын хүлээх хариуцлага**

- 6.1. Гүйцэтгэгч гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд биелүүлээгүй үүргийн дүнгийн 0.3 хувийн алдангийг захиалагчид төлнө. Захиалагч алдангийг ажлын хөлснөөс суутгал хийх хэлбэрээр гүйцэтгэнэ.
- 6.2. Захиалагч гэрээт ажлын хөлсийг хугацаанд нь шилжүүлээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд энэхүү биелүүлээгүй үүргийн дүнгийн 0.3 хувийн алдангийг Гүйцэтгэгчид төлнө. Алдангийг гүйцэтгэгчийн ажлын хөлсөнд нэмж төлөх хэлбэрээр гүйцэтгэнэ.
- 6.3. Гүйцэтгэгчийн төлсөн алданги нь гэрээт ажлыг гүйцэтгэх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.4. Гэрээт ажилд ямар нэгэн доголдол байвал/дүнг хангалтгүй гэж үзвэл/ энэ тухай Гүйцэтгэгчид мэдэгдэж, ажлыг бүрэн гүйцэтгүүлэх, гарсан доголдлыг Захиалагчаас тогтоосон хугацаанд өөрийн зардлаар уг доголдолыг арилгахыг шаардах эрхтэй.
- 6.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.



### Долоо. Бусад заалт

- 7.1 Талууд энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 7.2 Гүйцэтгэгч болон захиалагч талууд гэрээг баталж гарын үсэг зурсан өдрөөс захиалагч талд ажлыг албан ёсоор хүлээлгэн өгөх, түүнчлэн уг гэрээний 3.1-д заасан хүчинтэй хугацаа дуустал уг гэрээ хүчин төгөлдөр байна.
- 7.3 Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 7.4 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 7.5 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 7.6 Гэрээний нөхцөл зөрчигдсөнтэй холбоотой маргааныг талууд үл маргалдах журмаар шийдвэрлэх бөгөөд талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

**Захиалагчийг төлөөлж:**



.....  
/Гарын үсэг/

З.Эрдэнэчулуун  
/Албан тушаал/  
ЗУХАГ-ын дарга



.....  
/Гарын үсэг/

Б.Батзориг  
/Албан тушаал/  
ЗУХАГ-ын мэргэжилтэн

**Хаяг:**

УБ хот, Сүхбаатар дүүрэг,  
6-р хороо, Багатойруу 14201,  
Д.Сүхбаатарын гудамж-13,  
Метро бизнес төв, 5-р давхар  
**Утас:** 11-304258

**Гэрээ байгуулсан талууд**

**Гүйцэтгэгчийг төлөөлж:**



.....  
/Гарын үсэг/

Ч.Цэнхэрцэцэг  
/Албан тушаал/  
Менежер

**Хаяг:**

УБ хот, Баянгол дүүрэг  
10-р хороо,  
6-08 тоот

**Утас:** 99089712, 99175796

